

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/182/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: Munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khulvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/181
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БҮРЭНТОГТОХ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.НЯМДАЛАЙ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 217,510.5 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 27,079.4 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлж 14,129.4 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 12,950.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Бүрэнтогтох сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 86.2 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red ink stamp and signature. The stamp is rectangular and contains the text "АДБОУС" and "Төрийн аудитын байгууллага" in Mongolian. A handwritten signature in red ink is written over the stamp.

А. ЭРДЭНЗБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	364,966,044.20	395,342,160.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,500,859.95	50,938,494.53
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,500,859.95	50,938,494.53
3121	Төгрөг	22,500,859.95	50,938,494.53
31211	Төрийн сангийн харилцах	22,500,859.95	50,938,494.53
33	АВЛАГА	214,029,435.87	217,510,501.07
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	214,029,435.87	217,510,501.07
35	БАРАА МАТЕРИАЛ	128,435,748.38	126,893,165.08
351	Түүхий эд материал	28,669,236.55	42,621,066.77
35130	Эм боох материал	28,669,236.55	42,621,066.77
354	Хангамжийн материал	98,088,086.83	80,262,098.31
35410	Бичиг хэргийн материал	2,505,730.00	2,542,050.00
35420	Аж ахуйн материал	41,277,344.02	38,196,271.36
35450	Барилгын засварын материал	6,105,000.00	5,640,500.00
35460	Хүнсний материал	3,418,535.00	4,156,767.91
35470	Бусад хангамжийн материал	44,781,477.81	29,726,509.04
35600	Мал амьтад	1,678,425.00	4,010,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,494,851,826.19	1,759,236,195.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,494,851,826.19	1,759,236,195.29
392	Биет хөрөнгө	1,458,961,826.19	1,722,896,195.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,676,051,915.00	1,972,143,204.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-454,258,996.96	-519,800,986.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,684,000.00	83,684,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,969,499.97	-74,916,833.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	266,067,155.00	334,605,405.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74,378,730.72	-106,825,926.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,364,712.56	47,829,937.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,914,805.85	-18,365,570.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,753,867.00	14,753,867.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,437,789.87	-10,210,900.79
393	Биет бус хөрөнгө	35,890,000.00	36,340,000.00
39301	Програм хангамж	550,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,890,000.00	35,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,859,817,870.39	2,154,578,355.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,988,939.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,988,939.18
413	Өглөг	00.00	2,988,939.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,988,939.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,859,817,870.39	2,151,589,416.79
51	Засгийн газрын хувь оролцоо	1,859,817,870.39	2,151,589,416.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,702,788.00	212,702,788.00
51101	Өмч: - төрийн	212,702,788.00	212,702,788.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,529,865,182.07	1,821,636,728.47
51210	Өмнөх үеийн үр дүн	1,529,865,182.07	1,529,865,182.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	291,771,546.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,249,900.32	117,249,900.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,859,817,870.39	2,154,578,355.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,324,764,420.76	1,626,124,072.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	187,853,991.95	461,947,927.56
120	Нийтлэг татварын бус орлого	187,853,991.95	461,947,927.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	187,853,991.95	461,947,927.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,181,000.00	104,569,527.90
1200017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	128,650,060.00	337,573,164.40
1200018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	22,022,931.95	19,805,235.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,136,910,428.81	1,164,176,145.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	78,686,300.00	58,500,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,686,300.00	58,500,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,058,224,128.81	1,105,675,545.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,058,224,128.81	1,105,675,545.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,179,799,765.17	1,318,112,890.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,179,799,765.17	1,318,112,890.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,119,143,708.20	1,214,318,640.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,623,341.01	778,862,422.00
210101	Үндсэн цалин	368,776,113.01	429,875,481.00
210102	Нэмэгдэл	255,050,268.00	231,340,450.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,271,600.00	29,350,000.00
210104	Урамшуулал	59,525,360.00	88,296,491.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,177,955.00	98,164,156.92
210201	Тэтгэврийн даатгал	61,396,300.00	83,053,396.20
210205	Эрүүл мэндийн даатгал	14,781,655.00	15,110,760.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,676,243.03	49,639,539.18
210301	Гэрэл, цахилгаан	3,860,806.23	4,248,995.12
210302	Түлш, халаалт	45,269,199.80	45,213,583.36
210303	Цэвэр, бохир ус	546,237.00	176,960.70
2104	Хангамж, бараа материалын зардал	67,655,210.79	65,370,703.04
210401	Бичиг хэрэг	3,159,350.00	8,790,798.00
210402	Тээвэр, шатахуун	17,024,850.00	18,747,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,883,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	543,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,592,993.00	12,812,362.66
210408	Бараа материал актальсны зардал	31,238,017.79	21,593,522.38
2105	Нормативт зардал	87,901,539.86	69,397,302.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,326,971.46	58,059,790.03
210502	Хоол, хүнс	12,574,568.40	11,337,512.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,600,443.00	11,469,600.00
210604	Урсгал засвар	14,600,443.00	11,469,600.00
2107	Томилолт, зочны зардал	3,499,500.00	6,867,900.00
210702	Дотоод албан томилолт	3,499,500.00	6,867,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,349,442.00	11,866,982.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,095,000.00	10,197,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	150,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,474.00	146,874.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	165,658.00	165,658.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	571,360.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,660,033.51	122,680,034.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,478,525.00	280,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,181,508.51	122,400,034.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,656,056.97	103,794,250.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,146,000.00	97,263,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	47,145,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,146,000.00	50,118,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,510,056.97	6,531,250.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,510,056.97	6,531,250.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>144,964,655.59</u>	<u>308,011,182.84</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	290,199.88	16,239,636.44
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	290,199.88	1,568,761.04
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	14,670,875.40
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-290,199.88	-16,239,636.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>144,674,455.71</u>	<u>291,771,546.40</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>509,684,987.76</u>	<u>1,265,264,608.10</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	104,569,527.90
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	104,569,527.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	104,569,527.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	104,569,527.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	509,649,987.76	1,160,695,080.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,104,600.00	58,500,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,104,600.00	58,500,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	464,545,387.76	1,102,194,480.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	464,545,387.76	1,102,194,480.20
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>440,360,200.42</u>	<u>1,186,046,973.52</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,360,200.42	1,186,046,973.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,360,200.42	1,082,252,723.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,725,544.00	778,862,422.00
210101	Үндсэн цалин	170,581,847.00	429,875,481.00
210102	Нэмэгдэл	120,152,976.00	231,340,450.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,716,600.00	29,350,000.00
210104	Урамшуулал	17,274,121.00	88,296,491.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,941,200.00	98,164,156.92
210201	Тэтгэврийн даатгал	29,095,100.00	83,053,396.20
210205	Эрүүл мэндийн даатгал	6,846,100.00	15,110,760.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,767,552.42	46,650,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,384,312.42	4,248,995.12
210302	Түлш, халаалт	21,383,240.00	42,224,644.18

210303	Цэвэр, бохир ус	00.00	176,960.70
2104	Хангамж, бараа материалын зардал	14,686,590.00	35,481,130.00
210401	Бичиг хэрэг	1,012,500.00	6,277,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,609,000.00	16,447,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	2,883,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	543,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,745,090.00	9,329,210.00
2105	Нормативт зардал	39,662,730.00	74,989,354.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,105,794.00	60,359,019.00
210502	Хоол, хүнс	5,831,936.00	10,396,335.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,725,000.00	4,234,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,376,800.00	21,781,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,024,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,085,000.00
210604	Урсгал засвар	6,376,800.00	16,672,100.00
2107	Томилолт, зочны зардал	344,000.00	6,867,900.00
210702	Дотоод албан томилолт	344,000.00	6,867,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,874,234.00	15,773,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	872,500.00	12,497,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	150,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,474.00	146,874.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	55,000.00
210807	Газрын төлбөр	00.00	165,658.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	756,310.00	1,606,668.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,981,550.00	3,682,410.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,981,550.00	3,682,410.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	103,794,250.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	97,263,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	47,145,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	50,118,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	6,531,250.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,531,250.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	69,324,787.34	79,217,634.58
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,949,900.00	50,780,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,949,900.00	50,780,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,949,900.00	50,780,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,949,900.00	50,780,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,949,900.00	-50,780,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	67,374,887.34	28,437,634.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	89,161,160.92	22,500,859.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,689,948.26	50,938,494.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,702,788.00	119,858,516.26	1,475,869,165.48	1,808,430,469.74
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-32,042,364.65	-32,042,364.65
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,702,788.00	117,249,900.32	1,529,865,182.07	1,859,817,870.39
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	291,771,546.40	291,771,546.40
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,702,788.00	117,249,900.32	1,821,606,728.47	2,151,589,416.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,438,161,800.00	1,206,764,008.10	231,397,791.90	83.91
12	Татварын бус орлого	1,438,161,800.00	1,206,764,008.10	231,397,791.90	83.91
120	Нийтлэг татварын бус орлого	76,440,700.00	104,569,527.90	-28,128,827.90	136.80
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	76,440,700.00	104,569,527.90	-28,128,827.90	136.80
122	Тусламжийн орлого	1,361,721,100.00	1,102,194,480.20	259,526,619.80	80.94
122001	Хандив тусламж /дотоод/	1,361,721,100.00	1,102,194,480.20	259,526,619.80	80.94
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,460,662,700.00	1,178,326,373.52	282,336,326.48	80.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,460,662,700.00	1,178,326,373.52	282,336,326.48	80.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,363,356,700.00	1,081,063,373.52	282,293,326.48	79.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,496,900.00	778,862,422.00	90,634,478.00	89.58
210101	Үндсэн цалин	499,979,100.00	429,875,481.00	70,103,619.00	85.98
210102	Нэмэгдэл	257,336,600.00	231,340,450.00	25,996,150.00	89.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,191,700.00	29,350,000.00	-20,158,300.00	319.31
210104	Урамшуулал	102,989,500.00	88,296,491.00	14,693,009.00	85.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,283,300.00	98,164,156.92	19,119,143.08	83.70
210201	Тэтгэврийн даатгал	81,165,700.00	67,895,464.35	13,270,235.65	83.65
210202	Тэтгэмжийн даатгал	9,029,400.00	7,544,929.87	1,484,470.13	83.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,514,700.00	3,840,986.51	673,713.49	85.08
210204	Ажилгүйдлийн даатгал	4,514,700.00	3,772,015.47	742,684.53	83.55
210205	Эрүүл мэндийн даатгал	18,058,800.00	15,110,760.72	2,948,039.28	83.68
2104	Хангамж, бараа материалын зардал	70,740,700.00	35,481,130.00	35,259,570.00	50.16
210401	Бичиг хэрэг	16,893,700.00	6,277,900.00	10,615,800.00	37.16
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	16,447,720.00	8,552,280.00	65.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,016,100.00	2,883,100.00	1,133,000.00	71.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,068,000.00	543,200.00	4,524,800.00	10.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,762,900.00	9,329,210.00	10,433,690.00	47.21

2105	Нормативт зардал	130,964,000.00	74,989,354.60	55,974,645.40	57.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,307,800.00	60,359,019.00	45,948,781.00	56.78
210502	Хоол, хүнс	17,656,000.00	10,396,335.60	7,259,664.40	58.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,000,200.00	4,234,000.00	2,766,200.00	60.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	129,679,600.00	67,242,350.00	62,437,250.00	51.85
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,791,600.00	52,804,000.00	13,987,600.00	79.06
210602	Тавилга	36,595,300.00	00.00	36,595,300.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,111,100.00	3,085,000.00	7,026,100.00	30.51
210604	Урсгал засвар	16,181,600.00	11,353,350.00	4,828,250.00	70.16
2107	Томилолт, зочны зардал	9,500,000.00	6,867,900.00	2,632,100.00	72.29
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	6,867,900.00	2,632,100.00	72.29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,541,400.00	15,773,650.00	8,767,750.00	64.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,458,600.00	12,497,000.00	5,961,600.00	67.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,100,000.00	1,152,000.00	1,948,000.00	37.16
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	150,450.00	99,550.00	60.18
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,400.00	146,874.00	103,526.00	58.66
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	78,400.00	55,000.00	23,400.00	70.15
210807	Газрын төлбөр	250,000.00	165,658.00	84,342.00	66.26
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,154,000.00	1,606,668.00	547,332.00	74.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,150,800.00	3,682,410.00	7,468,390.00	33.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,150,800.00	3,682,410.00	7,468,390.00	33.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,306,000.00	97,263,000.00	43,000.00	99.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,306,000.00	97,263,000.00	43,000.00	99.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,188,000.00	47,145,000.00	43,000.00	99.91
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,118,000.00	50,118,000.00	00.00	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ	(22,500,900.00)	28,437,634.58		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,500,900.00	(28,437,634.58)		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	22,500,900.00	(28,437,634.58)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	22,500,859.95		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,938,494.53		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИИТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84
12	Татварын бус орлого	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84
122	Тусламжийн орлого	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84
122005	Төсвөөс санхүүжих	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,500,600.00	51,969,350.00	6,531,250.00	88.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,650,600.00	46,650,600.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,248,995.12	751,004.88	84.98
210302	Түлш, халаалт	40,850,600.00	42,224,644.18	-	103.36
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	176,960.70	623,039.30	22.12
2106	Эд хогшил худалдан авах	11,850,000.00	5,318,750.00	6,531,250.00	44.88
210604	Урсгал засвар	11,850,000.00	5,318,750.00	6,531,250.00	44.88
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		-	-	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		-	-	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		-	-	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,079.4 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчлийг илрүүлснээс 14,129.4 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 12,950.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

3.1 Залруулсан алдаа

Аудитын явцад илэрсэн дараах алдааг залруулсан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлтийг 2,994.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийж, үнэн зөв толилуулсан.
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээж авсан орлогын дүнг 2,594.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийж, үнэн зөв толилуулсан.
- Жилийн эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 6,531.2 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад тохируулгыг хийж, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөвөөр тайлагнасан.
- Нийгмийн эрүүл мэндийн зардлаас бэлтгэсэн 2,009.6 мянган төгрөгийн бичиг хэрэг, эм, хүнсний материалыг үр дүнгийн тайланд холбогдох зардалд нь бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийж холбогдох зардалд нь бүртгэсэн.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,950.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,093.1 мянган төгрөгөөс бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бүрэнтогтох сумын эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгууллагын нийт ажилчдыг Улаанбаатар хотод Улсын нэгдүгээр төв эмнэлэгт эрт илрүүлгийн үзлэгт хамруулах үзлэгийн төлбөр 10,650.0 мянган төгрөг, шатахууны зардал 2,300.0 мянган төгрөг, нийт 12,950.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх бараа, ажил үйлчилгээний зардлаас гаргахдаа Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2.4 дүгээр заалтыг үндэслэн шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалтад заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” гэж заасантай нийцэхгүй, “ үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Завсрын аудитаар:										
Зардлын бүртгэл, тайлагналтай холбоотой	7	14,084.1			7	14,084.1	7	14,084.1		
Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой	3	17,974.5			3	17,974.5	3	17,974.5		
Мөнгөн хөрөнгөтэй холбоотой	1	10,508.1			1	10,508.1	1	10,508.1		
Өглөгийн бүртгэлтэй холбоотой	1	10,508.1			1	10,508.1	1	10,508.1		
Дүн	12	53,074.8			12	53,074.8	12	53,074.8		
Жилийн эцсийн аудитаар:										
Худалдан авах ажиллагааны тайланг бэлтгэж ирүүлээгүй, санхүүгийн тайланг батлагдсан маягтаар бэлтгээгүй.	1	0.00			1	0.00	1	0.00		

Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн.	1	2,994.1			1	2,994.1	1	2,994.1		
Үнэ төлбөргүй хүлээж авсан орлогыг зөрүүтэй бүртгэсэн.	1	2,594.5			1	2,594.5	1	2,594.5		
Төсвийн гүйцэтгэлд тохируулга хийгээгүй	1	6,531.2			1	6,531.2	1	6,531.2		
Нийгмийн эрүүл мэндийн зардлаас бэлтгэсэн бичиг хэрэг, эм, хүнсний материалыг үр дүнгийн тайланд холбогдох зардалд нь бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн.	1	2,009.6			1	2,009.6	1	2,009.6		
Дүн	5	14,129.4			5	14,129.4	5	14,129.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн заалтыг үндэслэж ажиллагсдыг эрүүл мэндийн эрт илрүүлгийн үзлэгт хамруулах гүйлгээг хийсэн нь төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн байна.	1	12,950.0					1	12,950.0
Дүн	1	12,950.0					1	12,950.0

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			